

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2020	Сар	03	Өдөр	29
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	Амар Даатгал ХХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	Ипотекийн зээлдэгчийн гэнэтийн ослын даатгал					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын журам батлах тухай		2018-07-16		ЗТ-433-2018	
6	Цахимаар борлуулах эсэх	Тийм					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Доржготов		Уранцэцэг			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Зээлдэгчийн амь нас, эрүүл мэнд					
	Даатгалын үндсэн эрсдэл	Ахуйн, үйлдвэрлэлийн, зам тээврийн, байгалийн, 3 дагч					
	Даатгалын нэмэлт эрсдэл	Цус харвах, зүрх гэнэт хаагдах					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	0.07%-0.32%					

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛҮҮД

1. Аливаа ердийн болон архаг өвчний улмаас нас барсан эсвэл хөдөлмөрийн чадвараа бүр болон түр хугацаагаар алдсан;
2. Амиа хорлосон, амиа хорлохоор завдсан;
3. Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол болох орчин нөхцөлийг зориуд бүрдүүлсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотлогдсон;
4. Согтуурсан эсвэл мансуурсан үедээ бэртэж, гэмтсэнээс нас барсан эсвэл хөдөлмөрийн чадвараа бүр болон түр хугацаагаар алдсан;
5. Даатгуулагч даатгагчид даатгалын зүйл болон хохирлын талаар худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
6. Даатгалын зүйлийн даатгалын тохиолдолд хамрагдахгүй шалтгааны улмаас хохирол учирсан;
7. Учирсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
8. Зээлдэгчийн амь нас, хөдөлмөрийн чадвар бүрэн алдалтын даатгалын хувьд даатгалын гэрээт баталгаанд нэр нь бичигдээгүй зээлдэгчид учирсан хохирол;
9. Даатгуулагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр даатгалын тохиолдол болсныг нэн даруй мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;
10. Даатгуулахаас өмнөх хор нөлөө арилаагүй;
11. Даатгуулагч даатгалын хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй тохиолдол;
12. Нотолгоогүй хохирол;
13. Хууль, журам, гэрээний үүргээ зөрчсөн бусад үйлдэл;
14. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан эрсдэл;
15. Мэргэжлийн болон эрсдэлтэй спорт, уралдаан, тэмцээнд оролцох, ан хийх үеийн эрсдэл;
16. Учирсан хохирлоос үүдэн гарсан эдийн засгийн хохирол, олох ёстой байсан орлого болон бусад үр дагавар;
17. Даатгалын гэрээнд зааснаас бусад эрсдэл;
18. Жирэмслэлтээс хамгаалах мэс ажилбарын улмаас хохирол учирсан;
19. ХДХВ-ын халдвар авах болон ДОХ, бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсний улмаас хохирол учирсан;
20. Бие махбодын болон сэтгэцийн бүх төрлийн өвчнөөс үүдэлтэй эрсдэл
21. Даатгуулахаас өмнө учирсан бэртэл гэмтлийн үр дагавар;
22. Цацраг идэвхит бодисын хордлого, бохирдолт зэргээс учирсан хохирол, үр дагавар;
23. Цөмийн эрсдэл;
24. Дайн байлдаан, үймээн самуун, бослого, ажил хаялт, улс төрийн болон террорист үйл ажиллагааны үр дагавар;
25. Даатгагчтай тохиролцолгүйгээр хохирлын бодит хэмжээг тогтоох, батлах боломжгүй болгосон тохиолдол;
26. Даатгуулагчийн өөрийн алдаа, хайхрамжгүй үйлдэл, эс үйлдлээс даатгалын хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэх боломжгүй болгосон.